



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Галуут сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/174/СТА-ТШЗ

Баянхонгор хот 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024

Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор:

Б.Цэрэнчимэд

Утас: 88302569

Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г ГАЛУУТ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
О.АМАРЗАЯА ТАНАА

Г

2019.02.25 № 2/106

танай _____-ны № _____-т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Галуут сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Галуут сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Галуут сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад

D:\СТА-2018\Галуут сумын ИТХурал\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2519197

мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\СТА-2018\Галуут сумын ИТХурал\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Галуут сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ИТХ-ын нарийн бичгийн дарга О.Амарзаяад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галуут сумын ИТХурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Галуут сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар 15-наас 2019 оны 02 дугаар 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018, оны 02 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж,

Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Галуут сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 16 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Галуут сумын ИТХурлын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Галуут сумын ИТХурал нь “Нутгийн өөрийн удирдах ёсны байгууллагыг чадварлаг, нээлттэй, ил тод болгон төлөвшүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд тулгуурлан орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх, ард түмний аж амьдралыг дээшлүүлж, ая тухтай ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлж, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Галуут сумын ИТХурлын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Галуут сумын ИТХурлын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

Галуут сумын ИТХурал санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Галуут сумын ИТХурал нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний "Acolous" программ хангамж ашигладаг байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Галуут сумын ИТХурлын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй БНА-2019/174/СТА-ТШЗ

нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлын 2,0 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэж байна.

Галуут сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлангийн нийт зардал нь 74405,2 мянган төгрөг бөгөөд түүний 2,0 хувь болох 1,488.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэв.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	7.90	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	7.90	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар орж ирсэн 6000,0 мянган төгрөг болон үндсэн санхүүжилтийн данснаас 1940,0 мянган төгрөг нийт 7940,0 мянган төгрөгийн зарцуулалтын нотлох баримтын бүрдүүлэлт хангалтгүй байгаа зөрчил илэрлээ.

Энэ нь аж ахуйн нэгж байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх буюу "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13,1 "Анхан шатны бүртгэл нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13,7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Аудитын явцад илэрсэн дээрхи алдаа, зөрчилтэй асуудалд албан шаардлага өглөө.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Нэмэлт санхүүжилтийн дансаар орж зарцуулагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг багуудын дарга нарын хувийн харилцах дансруу шилжүүлж, зарцуулалтын тайлан гаргуулж аваагүй зөрчил илэрлээ.

Нэмэлт санхүүжилтийн дансны болон үндсэн даны зарцуулалтаас Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зарцуулалтын тайлан гаргуулж, тулган баталгаажуулт хийх шаардлагатай байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Галуут сумын ИТХурал чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Тайлант онд 62751,0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 60742,0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан бөгөөд оны эцэст 1231,2 мянган төгрөг хэмнэгдэж, буцаан төвлөрүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Галуут сумын ИТХурал нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс үнийн дүн бүхий орлогын 5 гүйлгээ байгааг хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж, 165,1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоогдсон бөгөөд хэрэгжилт 100,0 хувь байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Галуут сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Галуут сумын ИТХурлын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,177,565.00	1,088,342.42
33	АВЛАГА	181,535.00	525,862.42
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	181,535.00	525,862.42
35	БАРАА МАТЕРИАЛ	8,996,030.00	562,480.00
354	Хангамжийн материал	8,996,030.00	562,480.00
35410	Бичиг хэргийн материал	5,568,550.00	66,000.00
35420	Аж ахуйн материал	3,072,000.00	141,000.00
35470	Бусад хангамжийн материал	355,480.00	355,480.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,088,009.68	8,836,078.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,088,009.68	8,836,078.25
392	Биет хөрөнгө	7,088,009.68	8,836,078.25
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,704,500.00	7,498,802.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,666,916.49	-4,704,500.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,989,210.00	8,989,210.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,438,783.83	-6,997,433.75
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,500,000.00	4,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	16,265,574.68	9,924,420.67
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,265,574.68	9,924,420.67
51	Засгийн газрын хувь оролцоо	16,265,574.68	9,924,420.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,691,393.00	5,691,393.00
51101	Өмч: - төрийн	5,691,393.00	5,691,393.00
512	Хуримтлагдсан үр дүн	10,525,364.68	4,184,210.67
51210	Өмнөх үеийн үр дүн	10,525,364.68	10,525,364.68

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-6,341,154.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	48,817.00	48,817.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	16,265,574.68	9,924,420.67

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	70,148,000.00	68,064,160.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	70,148,000.00	68,064,160.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	6,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	6,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,888,800.00	60,742,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,888,800.00	60,742,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,259,200.00	1,322,160.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,259,200.00	1,322,160.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	64,410,158.50	74,405,314.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,410,158.50	74,405,314.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,750,158.50	71,851,874.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,585,412.00	37,049,675.84
210101	Үндсэн цалин	32,585,412.00	37,049,675.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,482,681.00	4,798,892.74
210201	Тэтгэврийн даатгал	3,482,681.00	4,798,892.74
2104	Хангамж, бараа материалын зардал	11,047,853.00	9,485,125.00
210401	Бичиг хэрэг	997,160.00	5,919,450.00
210402	Тээвэр, шатахуун	7,999,500.00	2,951,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	851,193.00	614,225.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	00.00
2105	Нормативт зардал	2,294,900.00	00.00
210502	Хоол, хүнс	2,294,900.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	1,150,000.00
210604	Урсгал засвар	00.00	1,150,000.00
2107	Томилолт, зочны зардал	925,500.00	1,144,000.00
210702	Дотоод албан томилолт	925,500.00	1,144,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	905,000.00	7,414,947.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	905,000.00	7,414,947.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,508,812.50	10,809,233.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,830,000.00	8,931,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	832,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,678,812.50	1,046,233.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,660,000.00	2,553,440.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,799,200.00	1,322,160.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,259,200.00	1,322,160.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	540,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,860,800.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,860,800.00	00.00

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,231,280.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,231,280.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,737,841.50	-6,341,154.01
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	20,604,166.58	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	20,604,166.58	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	20,604,166.58	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	14,866,325.08	-6,341,154.01

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	70,148,000.00	68,064,160.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	70,148,000.00	68,064,160.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	6,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	6,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,888,800.00	60,742,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,888,800.00	60,742,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,259,200.00	1,322,160.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,259,200.00	1,322,160.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	70,148,000.00	65,269,860.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70,148,000.00	65,269,860.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,428,000.00	62,716,420.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,297,507.00	37,460,150.00
210101	Үндсэн цалин	29,659,913.00	33,282,660.00
210104	Урамшуулал	1,916,194.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	721,400.00	4,177,490.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,743,000.00	4,732,746.00
210201	Тэтгэврийн даатгал	3,743,000.00	3,137,372.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	411,967.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	286,285.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	89,822.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	807,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,682,093.00	3,767,601.00
210401	Бичиг хэрэг	741,400.00	416,800.00
210402	Тээвэр, шатахуун	7,999,500.00	2,808,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	941,193.00	542,301.00
2105	Нормативт зардал	1,578,590.00	00.00
210502	Хоол, хүнс	1,578,590.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	925,500.00	1,144,000.00
210702	Дотоод албан томилолт	925,500.00	1,144,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,314,310.00	7,106,999.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,314,310.00	7,106,999.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,687,000.00	7,004,924.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,292,000.00	6,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	395,000.00	1,004,924.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,720,000.00	2,553,440.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,859,200.00	1,322,160.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,259,200.00	1,322,160.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,860,800.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,860,800.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,231,280.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,231,280.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	2,794,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	2,794,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	2,794,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	2,794,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	2,794,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-2,794,300.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,691,393.00	48,817.00	25,391,689.76	31,131,899.76
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,691,393.00	48,817.00	25,391,689.76	31,131,899.76
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	7,072,039.15	7,072,039.15
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,691,393.00	48,817.00	10,525,364.68	16,265,574.68
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,691,393.00	48,817.00	10,525,364.68	16,265,574.68
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,691,393.00	48,817.00	10,525,364.68	16,265,574.68
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,341,154.01	-6,341,154.01
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,691,393.00	48,817.00	4,184,210.67	9,924,420.67

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	62,751,000.00	59,435,773.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,751,000.00	59,435,773.42

Галуут сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,751,000.00	59,435,773.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,372,085.00	37,385,203.42
210101	Үндсэн цалин	34,112,200.00	33,207,713.42
210105	Гэрээт ажлын хөлс	5,259,885.00	4,177,490.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	4,732,746.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	3,137,372.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	411,967.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	286,285.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	89,822.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	807,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,767,515.00	3,767,601.00
210401	Бичиг хэрэг	416,800.00	416,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,808,415.00	2,808,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	542,300.00	542,301.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,294,300.00	4,294,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,794,300.00	2,794,300.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,172,100.00	1,144,000.00
210702	Дотоод албан томилолт	1,172,100.00	1,144,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,107,000.00	1,106,999.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,107,000.00	1,106,999.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8000000.00	7004924.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	6,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,004,924.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	62,751,000.00	59435773.42
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	62,751,000.00	59435773.42
132001	Орон нутгийн төсвөөс	62,751,000.00	59435773.42
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	02	02
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	01	01
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	03	03
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	01	01
650010	Гэрээт ажилтан	01	01
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	01	01